ADB

# ТЕНДЕРИЙН УРИЛГА

| | |
|---|---|
| **Огноо:** | 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр |
| **Төслийн дугаар, нэр:** | L3072-MON: Төлбөрийн системийн шинэчлэл төсөл |
| **Тендер шалгаруулалтын дугаар, нэр:** | NETC/Goods/2018-005.3: Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн Улаанбаатар хотод байрлах үндсэн дата төвийг шинэчлэх |
| **Тендерийн материал ирүүлэх сүүлийн хугацаа:** | 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн Улаанбаатарын цагаар 15:00 цаг |

1 Монгол Улсын Засгийн газар нь Азийн хөгжлийн банк (АХБ)-ны зээлийн санхүүжилтээр Төлбөрийн системийн шинэчлэл төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд, энэхүү төслийн хүрээнд NETC/Goods/2018-005.3 дугаартай Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ)-ийн Улаанбаатар хотод байрлах үндсэн дата төвийг шинэчлэх ажлыг санхүүжүүлнэ. ҮЦГТ-ийн үндсэн дата төв нь одоо шинээр баригдаж байгаа ҮЦГТ-ийн офисын барилгын 6-р давхарт байрлана. Тендерт оролцогч нь Tier II түвшний TIA 942 стандартыг хангасан дата төвийг байгуулна. Нийлүүлэлт, үйлчилгээний цар хүрээ нь тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, суурилуулалт, тохируулга, ашиглалт, үйлчилгээ зэргийг хамарсан байна.

2 Монголбанк эрх бүхий тендерт оролцогчдоос Монголбанкны ҮЦГТ-ийн үндсэн дата төвийг шинэчлэх ажлыг гүйцэтгэх зорилгоор битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендерт оролцогч нь "Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрөл: 2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт. Тусгай зөвшөөрөл нь гэрээт ажлыг хийж дуустал юмуу эсхүл 2020 оны 6-р сар хүртэл хүчинтэй байна. Түүнчлэн "Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрөл: 2.2.7. Хөргөх байгууламжийн технологийн тоног төхөөрөмжийн угсралт. Тусгай зөвшөөрөл нь гэрээт ажлыг хийж дуустал эсхүл 2020 оны 6-р сар хүртэл хүчинтэй байна.

3 Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтыг АХБ-ны нэг шаттай, нэг дугтуйт горимын дагуу явуулах бөгөөд эрх бүхий орны харьяат нийт тендерт оролцогчдод нээлттэй байна. Тендерт оролцогч нь 72,000,0000 (далан хоёр сая) төгрөгийн тендерийн баталгааг ирүүлнэ.

4 Зөвхөн доорх шаардлагуудыг хангасан тендерт оролцогч оролцох эрхтэй:

- Сүүлийн гурван жилийн хугацаанд тендерт оролцогчийн цэвэр өртөг (нийт актив хөрөнгөөс нийт өр төлбөрийг хасаж тооцсон) эерэг байх ёстой.
- Сүүлийн гурван жилд бараа нийлүүлэх гэрээ гүйцэтгэж дууссан эсхүл гүйцэтгэж байгаа гэрээний жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ нь 3,600,000,000.00 (гурван тэрбум зургаан зуун сая) төгрөг байна.
- Гэрээний хэрэгжилтийн явцад шаардлагатай мөнгөн гүйлгээний хэрэгцээг хангаж чадах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, авах боломжтой зээл, эсхүл бусад санхүүжилтийн нийт хэмжээ нь 2,200,000,000.00 (хоёр тэрбум хоёр зуун сая) төгрөгөөс доошгүй байна.
- Сүүлийн гурван жилд бараа нийлүүлэх үндсэн гүйцэтгэгчээр сүлжээний тоног төхөөрөмж, үл тасалдах тэжээлийн үүсгүүр, дата төвийн хөргөлтийн системийг нийлүүлж, суурилуулж амжилттай хийж дуусгасан 2 (хоёр) гэрээтэй байна. Гэрээ тус бүрийн нийт үнийн дүн нь 2,900,000,000.00 (хоёр тэрбум есөн зуун сая) төгрөгөөс доошгүй байна. Гэрээний агуулга ба иж бүрдэл нь тендертэй ижил байна.

5 Сонирхсон эрх бүхий тендерт оролцогч нь Улаанбаатарын цагаар 09:00 – 17:00 цагийн хооронд Бямба, Ням гараг болон амралтын өдрүүдээс бусад өдрүүдэд дараах хаягт хүрэлцэн ирж тендерийн баримт бичигтэй танилцах, нэмэлт мэдээлэл авах боломжтой:

**Хаяг: Монгол Улс, 15160, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,**
**Жигжиджавын гудамж 3, Бодь цамхаг, 10-р давхар, 1003,**
**Монголбанкны “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”**
**Худалдан авалтын мэргэжилтэн Ц.Цог**
**Утас: +976-70119910; Факс: 976-11-311471**
**И-мэйл: procurement@psmp.mn**

6 Тендерийн өмнөх уулзалт 2019 оны 4-р сарын 22-ны өдрийн 15:00 цагт доорх хаягт болно:
*Боди Цамхаг, Жигжиджавын гудамж 3, Чингэлтэй Дүүрэг*
*Улаанбаатар 15160, Монгол Улс, 1002 тоот, 10 давхар, Уулзалтын өрөө*

7 Сонирхсон тендерт оролцогч нь бичгээр хүсэлтээ гаргаж, 300,000 (гурван зуун мянган) төгрөгтэй тэнцэх хураамжийг эргэн үл төлөгдөх нөхцөлтэйгөөр төлсөнөөр Монгол хэл дээр бэлтгэгдсэн тендерийн баримт бичгийг худалдан авч болно. Тендерийн баримт бичгийг худалдан авах эрх бүхий этгээд нь:

- **NETC/Goods /2018-005.3** дугаартай тендерийн баримт бичгийг худалдан авах хүсэлтээ албан бичгээр уг тендерийн урилгад заасан хаягаар ирүүлнэ.
- Төлбөр хүлээн авах данс:
  ***Банкны нэр:** Төрийн банк*
  ***Дансны дугаар:** 109000067145*
  ***Дансны нэр:** Төлбөрийн системийн шинэчлэл төсөл*
- Баримт бичгийг ердийн шуудангаар дотоодод илгээх бөгөөд гадаад улсад илгээх тохиолдолд нэмэлт 250,000 (хоёр зуун тавин мянган) төгрөгөөр буухиа шуудангаар хүргүүлэх болно. Монголбанк нь баримт бичиг алга болох эсхүл хугацаа хоцорч хүргэгдсэнтэй холбоотой ямар нэг хариуцлага хүлээхгүй.
- Тендерийн баримт бичгийг хүлээн авахаар томилогдсон хүн нь дараах баримт бичгийг авч ирэх ёстой. Үүнд:
  *(i) Компанийн танилцуулга*
  *(ii) Тендерийн баримт бичиг худалдан авах хүсэлт, албан бичиг*
  *(iii) Иргэний үнэмлэх эсвэл паспорт*

8 Тендерийг **2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 15:00 цагт** эсхүл түүнээс өмнө доорх хаягаар ирүүлнэ. Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана. Тендерийг **2019 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 15:00 цагт** доор заасан хаягаар хүрэлцэн ирж, нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ:
*Боди Цамхаг, Жигжиджавын гудамж 3, Чингэлтэй Дүүрэг*
*Улаанбаатар 15160, Монгол Улс, 1003 тоот, 10 давхар*

9 Тендер бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор тендерт оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Монголбанк хариуцахгүй.